

Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны
06 дугаар сарын 11-ний өдрийн 225
дугаар тогтоолоор баталсан "Үнэт цаасны
бүртгэлийн журам"-ын 4 дугаар хавсралт

Хагас жилийн үйл ажиллагааны тайлагнал /маягт 2/		
Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.		
Тайлагнах хугацаа	2025 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2025 оны 6 дугаар сарын 30-ны өдөр	
Үнэт цаас гаргагчийн мэдээлэл	Үнэт цаас гаргагчийн нэр: ХасБанк ХК УБГД: 9007001007 Үнэт цаасны симбол: ХАС Утасны дугаар: +976-75771888	
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Монголын хөрөнгийн бирж ХК	
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Банк, санхүү	
Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргасан СЗХ-нд бүртгэлтэй аудитын компанийн нэр, бүртгүүлсэн огноо	Эрнст энд Янг Монголия Аудит ХХК, бүртгүүлсэн огноо: 2013 оны 5 дугаар сарын 08	
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	1,052,700,000	
Жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Бэлтгэсэн: Г.Тамир /Санхүү удирдлага, олон улсын харилцааны газрын захирал/ Хянасан: Г.Эрдэнэбаяр /Санхүү хариуцсан захирал/ Хянасан: Н.Мөнхцэлмэг /Хууль хариуцсан захиал бөгөөд ТУЗ-ийн нарийн бичгийн дарга/	
1.	Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайлан	
	Санхүүгийн байдлын үзүүлэлт Орлогын тайлан Өмчийн өөрчлөлтийн тайлан Мөнгөн гүйлгээний тайлан	2025 оны хагас жилийн санхүүгийн тайланг хавсаргав. /Хавсралт №1/
2.	Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайланг хэлэлцэж, баталгаажуулсан төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлт	
	2025 оны хагас жилийн санхүүгийн тайланг хөндлөнгийн хараат бус аудитор хянах ажил хийгдэж байна.	

3.	Тайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад, дотоод хүчин зүйлс, санхүүгийн тайлангийн шинжилгээ, орлого, зарлага, ашгийн үзүүлэлтүүдийг тооцож дүгнэсэн удирдлагын тайлан, дүгнэлт	
3.1.	Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/	Ашигт ажиллагаа: 2025 оны 1-р хагас жилд ХасБанк ХК-ийн татварын дараах цэвэр ашиг 85.9 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.7% өслөө. Банкны өөрийн хөрөнгийн өгөөж (aROE) жилийн 22.6%, нэгж хувьцаанд ногдох жилд шилжүүлсэн цэвэр ашиг (EPS) 163.4 төгрөг байна. Нийт актив: Тайлант хугацаанд ХасБанк ХК-ийн нийт актив 6,754.9 тэрбум төгрөгт хүрч оны эхнээс 6.9%-р буюу 433.1 тэрбум төгрөгийн өсөлт үзүүлсэн байна. Үүнд: Иргэдийн зээлийн багц 12.9%-р өсөж 2,920.7 тэрбум, Байгууллагын зээлийн багц 7.2% өсөж 689.6 тэрбум төгрөг, Хаслизингийн багц 30.9%-р өсөж 610.8 тэрбум төгрөгт тус тус хүрсэн нь активын өсөлтөд голлох нөлөөг үзүүлсэн байна. Иргэдийн зээлийн багцын өсөлтийн 56%-ийг жижиг бизнесийн зээл, 21%-ийг хадгаламж барьцаалсан зээл бүрдүүллээ. Хаслизингийн багцын өсөлтөд суудлын автомашины лизинг голлон нөлөөлсөн ба харилцагчдаа түргэн шуурхай үйлчилж, бэлтгэн нийлүүлэгч компаниудтай харилцааг бататган ажилласнаар салбартаа лизингийн үйлчилгээгээр тэргүүлж байна. Тайлант хугацаанд активын чанарын удирдлагыг оновчтой хэрэгжүүлж нийт зээл, санхүүгийн түрээсийн багцад эзлэх чанаргүй зээлийн харьцаа 2.2%-д барин ажилласан нь банкны системд тэргүүлэх үзүүлэлт юм. Харилцах хадгаламж: ХасБанк нь харилцагчдадаа бизнесийн болон хувийн дансаа шуурхай, найдвартай удирдахад зориулан харилцах дансны үйлчилгээг санал болгодог. Мөн харилцагчийн хуримтлалын зорилго, санхүүгийн төлөвлөгөөнд үндэслэн төрөл бүрийн хугацаатай хадгаламжийн дансны үйлчилгээ үзүүлдэг. Банкны бүтээгдэхүүн үйлчилгээг авах цахим сувгийг нэмэгдүүлэхээс гадна өдөр тутмын төлбөр тооцоог хялбарчлах InstaXpay, 7-17 насны хүүхдүүдэд чиглэсэн Xacteen аппликейшнуудыг зах зээлд нэвтрүүлсэн, хадгаламжийн бүтээгдэхүүний урамшуулалт аян эхлүүлсэн зэрэг харилцагчдад чиглэсэн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсний үр дүнд 2025 оны эхний хагас жилийн байдлаар банкны нийт хадгаламжийн үлдэгдэл 5.0%-р өсөж 2,688.5 тэрбум төгрөгт хүрсэн байна. Харилцах дансны үлдэгдэл оны эхний хагас жилийн байдлаар 732.9 тэрбум төгрөг байсан бол тайлант хугацаанд бизнесийн эрэлт хэрэгцээнээс хамаарч 650-815 тэрбум төгрөгийн хооронд хэлбэлзэж байсан. Гадаад эх үүсвэр: Тайлант хугацаанд нийт 213.2 сая ам.долларын урт хугацаатай эх үүсвэрийг EBRD, ASIAN DEVELOPMENT BANK, FINNFUND болон DWM зэрэг олон улсын нэр хүнд бүхий банк, санхүүгийн байгууллагуудаас татан төвлөрүүлэн ажиллалаа. Банк тус эх үүсвэрүүдийг залуу бизнес

		эрхлэгч болон бичил, ЖДБ болон ногоон эдийн засгийг санхүүжүүлэхэд зарцуулна.		
3.2.	Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт		Монголбанкнаас тогтоосон байвал зохих хэмжээ	ХасБанкны 2025-06-30-ны байдлаарх үзүүлэлт
		Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын зохистой харьцаа	>12.5%	18.3%
		Өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын харьцаа	>12%	18.3%
		Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа	>25%	36.0%
		Гадаад валютын нээлттэй позиц болон өөрийн хөрөнгийн харьцаа (нэгж валютаар)	+/- 15%	-4.9%
		Гадаад валютын нээлттэй позиц болон өөрийн хөрөнгийн харьцаа (нийт валютаар)	+/- 30%	-5.7%
		Нийт томоохон зээлдэгчдэд олгох активын төвлөрлийн харьцаа	<300%	46.3%
		Том 10 харилцагчийн хадгаламж, харилцахын төвлөрлийн харьцаа	<25%	6.8%
3.3.	Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл	Гадаад хүчин зүйлс: Монгол улсын эдийн засаг 2025 оны эхний улиралд 2.4 хувиар өссөн нь өмнөх оны 1-р улирлын өсөлттэй харьцуулахад огцом буурсан үзүүлэлт байлаа. Эдийн засгийн өсөлтөд салбаруудын хувь нэмрийг харвал үйлчилгээний салбар 3.1 нэгж хувь, хөдөө аж ахуйн салбар 1.0 нэгж, уул уурхайн салбар 0.1 нэгж хувийн эерэг нөлөө үзүүлсэн бол барилга, худалдаа болон тээврийн салбар эдийн засгийн өсөлтийг хязгаарлах чиглэлд 1.8 нэгж хувийн нөлөө үзүүлсэн байна. Дэлхийн зах зээл дээрх нүүрсний үнийн бууралт, тэр дундаа коксжих нүүрсний үнэ өмнөх оны мөн үеэс 38 хувиар буурсан нь уул уурхайн салбарын эдийн засагт үзүүлэх нөлөө буурахад нөлөөлөв. Энэ оны 5-р сарын байдлаар улсын хэмжээнд инфляцын түвшин 8.3 хувь, Улаанбаатар хотын инфляц 9.4 хувьд хүрээд байна. Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүн, импортын барааны үнийн өсөлт болон цахилгааны үнийн нэмэгдэл, түүний дам нөлөөгөөр инфляцын түвшин Монголбанкны зорилтот түвшин болох 6±2 хувийг он гарсаар давсан хэвээр байна. Инфляц зорилтот түвшнээс өндөр байгаа нь мөнгөний хатуу бодлого үргэлжлэх шалтгаан болж байна. Улмаар 2025 оны эхний хагас жилд Мөнгөний бодлогын хороо бодлогын хүүг 2 нэгж хувиар нэмэх, банкуудын төгрөгийн болон гадаад валютын заавал байлгах нөөцийг тус бүр 2 нэгж хувиар нэмэгдүүлэх, хэрэглээний зээлийн өр орлогын харьцааг 50 хувь хүртэл бууруулах зэрэг шийдвэрүүдийг гаргаад байна.		

	2025 оны эхний 5 сарын байдлаар нийт экспорт өмнөх оны мөн үеэс 15 хувиар буурч, 5.4 тэрбум ам.долларт, нийт импорт 3.3 хувиар өсөж 4.5 тэрбум ам.долларт хүрснээр гадаад худалдааны тэнцэл 885 сая ам.долларын ашигтай гарсан хэдий ч өмнөх оны мөн үетэй харьцуулахад 55 хувиар буурсан үзүүлэлт болов. Зэсийн баяжмалын экспортын орлого өмнөх оны мөн үеэс 61 хувиар өссөн нь экспортын орлогод эергээр нөлөөлсөн хэдий ч нүүрсний экспортын орлого өмнөх оны мөн үеэс 41 хувиар буурсан нөлөөллийг нөхөхөд хангалттай байсангүй. Төлбөрийн тэнцэл энэ оны эхний 4 сарын байдлаар 491 сая ам.долларын алдагдалтай гарч улмаар гадаад валютын албан нөөц (ГВАН) 2025 оны 5-р сард 5.2 тэрбум ам.долларт хүрч оны эхнээс 5.7 хувиар буурлаа. Үүнээс шалтгаалан ам.долларын ханш оны эхнээс 4.5 хувиар төгрөгийн эсрэг чангарав. Нүүрсний үнэ үргэлжлэн буурч, төлбөрийн тэнцлийн урсгал дансны алдагдлыг нэмэгдүүлж байгаа нь гадаад валютын ханш үргэлжлэн чангарах эрсдэлийг нэмэгдүүлж байна. Уул уурхайн салбарын орлого буурч байгаагаас шалтгаалан улсын төсвийн алдагдал эхний 5 сарын байдлаар 259 тэрбум төгрөгт хүрээд байна. Төсвийн алдагдал, төлбөрийн тэнцлийн алдагдал, инфляц зорилтот түвшнээс өндөр байгаа зэрэг нь цаашид макро эдийн засгийн орчны эрсдэлийг нэмэгдүүлэхээр байна. Дотоод хүчин зүйлс: 2025 оны эхний хагас жилд ХасБанк харилцагчдадаа санхүүгийн үйлчилгээг иж бүрэн хүргэх, харилцагчийнхаа төлбөр тооцооны үндсэн банк болох стратегийн зорилго тавьж уламжлалт салбарын сувгийн үйлчилгээг үргэлжлүүлэхээс гадна дижитал, цахим суваг, төлбөр тооцоо, картын бүтээгдэхүүнийг сайжруулахад чиглэсэн хөгжүүлэлт, төслүүд дээр ач холбогдол өгч ажиллалаа. Харилцагчийн өдөр тутмын төлбөр тооцоог хялбарчлах InstaXpay, хүүхэд залууст зориулсан Хастеен+ аппликейшн төслүүдийн эхний шат дуусаж зах зээлд амжилттай танилцууллаа. Мөн бичил, жижиг дунд бизнесийн сегментийн хувьд мерчантын үйлчилгээний үнэ цэнийг нэмэгдүүлэх мерчант веб, аппликейшн, залуу бизнес эрхлэгчдийг дэмжих зээлийн шинэ бүтээгдэхүүн зэргийг нэвтрүүлээд байна. Үр дүнд, нийт харилцагчдын тоо харилцагчийн тоо 57 мянгаар нэмэгдэж 1.5 сая хүрсэн ба “Залуу бизнес эрхлэгчдийг дэмжих зээл”, “Асуудалгүй” үйлчилгээ зэрэг шинэ бүтээгдэхүүнүүд нэвтрүүлснээр нийт зээлдэгчийн тоо 19%-иар өсөж 166 мянгад хүрлээ. Тогтвортой эх үүсвэрийг нэмэгдүүлэх, байнгын харилцагчаа урамшуулж, харилцагчийн бааз суурийг өргөжүүлэх зорилготой 1 тэрбум төгрөгийн шагналын сантай хадгаламжийн аян зарласан. Үүний үр дүнд ирээдүйн саятан хадгаламж эзэмшигч 200 мянга давж, хугацаатай хадгаламж, цалингийн хадгаламж, тэтгэвэр хуримтлалын данс эзэмшигчийн тоо 5.5 хувиар нэмэгдсэн байна. ХасБанк нь 2025 оны эхний хагас жилийн байдлаар Монгол улсын засгийн газраас хэрэгжүүлж буй “Ноос, ноолуур, арьс ширний боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих” Цагаан алт хөтөлбөрийн хүрээнд 27.8 тэрбум төгрөгийн эргэлтийн хөрөнгө, АТАР-4 аяны
--	---

		хүрээнд хэрэгжүүлж буй “Хөдөө аж ахуйн тогтвортой үйлдвэрлэлийг дэмжих хөрөнгө оруулалтын зээл” хөтөлбөрийн хүрээнд 8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын зээлийг хамтран ажилладаг байгууллагуудад олгосон байна. Энэхүү хөтөлбөрийн зээлээр 40 гаруй малчин, хоршоодоос 174 тонн түүхий ноос, ноолуур бэлтгэсэн бөгөөд жилд 2,500 тонн мах ангилан боловсруулах хүчин чадалтай, 2,000 тонн мах хадгалах хөргүүртэй агуулах бүхий боловсруулах үйлдвэр шинээр ашиглалт ороход бэлэн болоод байна.
3.4.	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл /off balance/	ХасБанкны тэнцлийн гадуурх дансны үлдэгдлийн тайланг хавсаргав /Хавсралт № 2/
4.	Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/	
	Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.2.4 дэх заалтад заасны дагуу ХасБанк нээлттэй хувьцаат компани болсноос хойш холбогдох этгээд болон сонирхлын зөрчилтэй хэлцлийн мэдээллийг банкны өөрийн цахим хуудсаар болон Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр олон нийтэд мэдээлдэг. Дараах холбоосоор орж танилцана уу. https://xacbank.mn/mn/ad-hoc https://mse.mn/mn/company/568 Түүнчлэн, Банкны холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгийн тайланг улирал бүр гарган өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлдэг. Тус тайлантай дараах холбоосоор орж танилцана уу. https://xacbank.mn/mn/the-loans-and-other-equivalent-assets-provided-to-the-related-parties Төлөөлөн удирдах зөвлөлөөс 2025 оны эхний хагас жилд нийт 9 сонирхлын зөрчилтэй болон холбогдох этгээдийн хэлцлийг баталсан. Ингэхдээ, Банкны тухай хуулийн 17.9-д заасан шаардлага буюу банкны ердийн үйл ажиллагааны хүрээнд бусад этгээдтэй хийх хэлцлээс хөнгөлөлттэй нөхцөлгүй байх шаардлагыг баримталсан. Тайлант хугацаанд их хэмжээний хэлцэл хийгдээгүй болно.	
5.	Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойш дуусах хүртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл	
	Тайлант хугацаанд нэмэлт хувьцаа гаргах замаар эх үүсвэр татан төвлөрүүлээгүй болно.	
6.	Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл	

Хувьцаа эзэмшлийн бүтэц

Тайлангийн өдрийн байдлаар ХасБанкны хувьцаа эзэмшигчид дараах бүтэцтэй байна:

#	Хувьцаа эзэмшигч	Хувьцааны тоо	Хувь	#	Хувьцаа эзэмшигч	ХасБанк дахь шууд бус хувь эзэмшил
1	TCH	1,000,000,000	94.99%	1	МАК Инвест Кей Эф Ти	19.37%
				2	Олон Улсын Санхүүгийн Корпораци	16.63%
				3	ОРИКС Корпораци	16.28%
				4	Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк	12.50%
				5	Канадын Үндэсний Банк	10.18%
				6	Ронкок Партнерз Кей Эф Ти	9.83%
				7	Монголия Файненшл Сервисиз Пи Ти И Эл Ти Ди	6.42%
				8	Триодос Фэр Шэр Фанд	3.61%
				9	Иргэн Магваны Болдоо	0.10%
				10	Иргэн Чулууны Ганболд	0.09%
2	Олон нийт	51,983,559	4.94%			
3	Халаасны хувьцаа	716,441	0.07%			
	Нийт	1,052,700,000	100.00%			

Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-ийн бүрэлдэхүүн



Санжай Гүпта
ТУЗ-ийн дарга



Майкл Мэдден
ТУЗ-ийн гишүүн



Н.Цэлмүүн
ТУЗ-ийн гишүүн



Б.Уламбаяр
ТУЗ-ийн хараат бус гишүүн



Нираж Вадва
ТУЗ-ийн хараат бус гишүүн



Анджей Витак
ТУЗ-ийн гишүүн



Г.Дэвэгжав
ТУЗ-ийн гишүүн



Албертус Браггинк
ТУЗ-ийн гишүүн



Сюзанна Херринг Карр
ТУЗ-ийн гишүүн



Эми Чой
ТУЗ-ийн хараат бус гишүүн



Доминик Жак
ТУЗ-ийн гишүүн



Стюарт Холл
ТУЗ-ийн хараат бус гишүүн

Жич: Гишүүдийн боловсрол, ажлын туршлага зэрэг дэлгэрэнгүй мэдээлэлтэй банкны вебсайтаар дамжуулан танилцах боломжтой.

2025 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн байдлаарх ТУЗ-ийн гишүүдийн ХасБанк дахь хувьцаа эзэмшил:

№	Овог нэр	Албан тушаал	Хувьцаа эзэмшил (шууд)
1	Санжай Гүпта	ТУЗ-ийн дарга	0.08%
2	Албертус Браггинк	ТУЗ-ийн гишүүн	-
3	Анджей Витак	ТУЗ-ийн гишүүн	-

4	Доминик Жак	ТУЗ-ийн гишүүн	-
5	Майкл Мадден	ТУЗ-ийн гишүүн	-
6	Сюзанна Карр	ТУЗ-ийн гишүүн	-
7	Г.Цэвэгжав	ТУЗ-ийн гишүүн	0.18%
8	Н.Цэлмүүн	ТУЗ-ийн гишүүн	-
9	Нираж Вэдва	ТУЗ-ийн хараат бус гишүүн	-
10	Стюарт Холл	ТУЗ-ийн хараат бус гишүүн	-
11	Б.Уламбаяр	ТУЗ-ийн хараат бус гишүүн	-
12	Эми Чой	ТУЗ-ийн хараат бус гишүүн	-

ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүн

№	Аудитын хороо	Эрсдэлийн удирдлагын хороо	Засаглал, цалин урамшууллын хороо	Нэр дэвшүүлэх Хороо
Дарга	Б.Уламбаяр (ХБГ)	Албертус Браггинк	Майкл Мадден	Стюарт Холл (ХБГ)
Гишүүд	Анджей Витак	Доминик Жак	Н.Цэлмүүн	Сюзанна Карр
	Сюзанна Карр	Б.Уламбаяр (ХБГ)	Б.Уламбаяр (ХБГ)	Албертус Браггинк
	Нираж Вэдва (ХБГ)	Нираж Вэдва (ХБГ)	Нираж Вэдва (ХБГ)	Б.Уламбаяр (ХБГ)
	Эми Чой (ХБГ)	Эми Чой (ХБГ)	Эми Чой (ХБГ)	Нираж Вэдва (ХБГ)
	Стюарт Холл (ХБГ)	Стюарт Холл (ХБГ)	Стюарт Холл (ХБГ)	Эми Чой (ХБГ)

Гүйцэтгэх удирдлагын бүрэлдэхүүн

Тайлант хугацаанд ХасБанк нь дараах удирдлагын бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаагаа удирдан зохион байгуулсан:

№	Овог нэр	Албан тушаал
1	Г.Цэвэгжав	Гүйцэтгэх захирал
2	Г.Эрдэнэбаяр	Санхүү хариуцсан захирал
3	Э.Уламбаяр	Иргэдийн банк хариуцсан захирал
4	Б.Еркин	Байгууллагын банк хариуцсан захирал
5	С.Дауренбек	Бизнес хөгжил хариуцсан захирал
6	Д.Мөнхзул	Лизинг хариуцсан захирал
7	Илия Аврамов	Эрсдэл хариуцсан захирал
8	Г.Зул	Үйл ажиллагаа хариуцсан захирал
9	Х.Өнөрбат	Мэдээллийн технологи хариуцсан захирал
10	Э.Ундармаа	Ерөнхий аудитор
11	Н.Мөнхцэлмэг	Хууль хариуцсан захирал бөгөөд ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

Удирдлагын багт орсон өөрчлөлт

Лизинг хариуцсан захирал С.Дауренбек нь Бизнес хөгжил хариуцсан захирлаар, Д.Мөнхзул нь Лизинг хариуцсан захирлаар шинээр тус тус томилогдсон. Энэ талаар 2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлсэн.

Гүйцэтгэх удирдлагын ХасБанкинд эзэмшиж буй хувьцааны хувь эзэмшлийг 2025 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар толилуулав:

	№	Овог нэр	Албан тушаал	Хувьцаа эзэмшил (шууд)
	1	Г.Цэвэгжав	Гүйцэтгэх захирал	0.18%
	2	Г.Эрдэнэбаяр	Санхүү хариуцсан захирал	0.09%
	3	Э.Уламбаяр	Иргэдийн банк хариуцсан захирал	0.07%
	4	Б.Еркин	Байгууллагын банк хариуцсан захирал	0.05%
	5	С.Дауренбек	Бизнес хөгжил хариуцсан захирал	0.06%
	6	Д.Мөнхзул	Лизинг хариуцсан захирал	0.02%
	7	Илия Аврамов	Эрсдэл хариуцсан захирал	0.00%
	8	Г.Зул	Үйл ажиллагаа хариуцсан захирал	0.05%
	9	Х.Өнөрбат	Мэдээллийн технологи хариуцсан захирал	0.04%
	10	Э.Ундармаа	Ерөнхий аудитор	0.04%
	11	Н.Мөнхцэлмэг	Хууль хариуцсан захирал бөгөөд ТУЗ-ийн нарийн бичгийн дарга	0.02%
7.	Үнэт цаас гаргагчийн засаглалтай холбоотой тайлан, мэдээлэл			
	ХасБанк нь хувьцаат компани болсноос хойш Санхүүгийн зохицуулах хорооны Компанийн засаглалын кодекст заасны дагуу 2023 болон 2024 оны хэрэгжилтийн үнэлгээний тайланг бэлтгэн гаргаж тухай бүр Монголын хөрөнгийн бирж болон өөрийн цахим хуудсаараа дамжуулан нийтэд мэдээлсэн. ХасБанкны “Компанийн засаглалын кодексийн хэрэгжилт”-ийн 2024 оны тайланг СЗХ-ноос хянан баталгаажуулж 93.1% буюу засаглал сайн, эрсдэлгүй гэж үнэлсэн нь өмнөх оноос 1.4%-иар өссөн үзүүлэлт юм. СЗХ-ноос өгсөн үүрэг даалгаврын дагуу зохиох бүтцийн өөрчлөлтийг хийж “Компанийн засаглалын кодексийн хэрэгжилт”-ийн 2024 оны тайланг шинэчлэн 2025 оны хагас жилийн байдлаар СЗХ-нд хүргүүлсэн. СЗХ-ноос хянан баталгаажуулалт хийгдсэний дараа шинэчилсэн тайлан болон үнэлгээг Монголын хөрөнгийн бирж болон өөрийн цахим хуудсаараа дамжуулан нийтэд мэдээлэн ажиллах болно.			

№	Гарчиг	Авбал зохи оноо	2023.06.30-ны байдлаар		2024.12.31-ний байдлаар		Өөрчлөлт хувь
			СЗХ-ны хяналтын оноо	Хэрэгжилт хувь	СЗХ-ны хяналт ын оноо	Хэрэгжилт хувь	
1	ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт	12	9	75%	10	83.3%	8.3%
2	ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг	10	7	70%	7	70%	-
3	Тайлагнал, мэдээллийн ил тод байдал	6	6	100%	6	100%	-
4	Аудит, хяналтын тогтолцоо	6	6	100%	6	100%	-
5	Эрсдэлийн удирдлага	8	8	100%	8	100%	-
6	Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал	6	6	100%	6	100%	-
7	Оролцогч талуудын эрх ашиг	8	8	100%	8	100%	-
8	Компанийн соёл	6	6	100%	6	100%	-
9	Хувьцаа эзэмшигчдийн эрх	10	10	100%	10	100%	-
Нэгдсэн дүн		72	66	91.7	67	93.1%	+1.4%

Хянан баталгаажуулалтын оноо болон дэлгэрэнгүй тайлантай дараах холбоосоор орж танилцана уу.

<https://mse.mn/mn/company/568>

<https://xacbank.mn/mn/governance-codex-report>

1. Хувьцаа эзэмшигчдийн хурал

ХасБанк хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2025 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр Шангри-Ла зочид буудлын их танхимд цахим болон танхим хосолсон хэлбэрээр амжилттай зохион байгуулагдсан. Хурлын ирц 96.01%-ийн ирцтэйгээр хүчин төгөлдөр бүрдэж, дараах 7 асуудлыг хэлэлцэн баталсан болно:

1. ХасБанкны 2024 оны үйл ажиллагааны тайланг Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийн хамт баталсан;
2. ХасБанкны 2024 оны аудитлагдсан санхүүгийн тайланг Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийн хамт баталсан;
3. ХасБанкны 2024 оны жилийн эцсийн цэвэр ашгаас нэгж хувьцаанд 27.00 төгрөгийг хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хэлбэрээр зарлан хуваарилах шийдвэр гаргасан;
4. ХасБанкны Дүрэмд Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хороог Нэр дэвшүүлэх хороо болон Засаглал, цалин урамшууллын хороо болгон бие даасан хоёр хороонд хувааж өөрчлөн байгуулах асуудлыг тусгаж нэмэлт, өөрчлөлт оруулсан;
5. ХасБанкны Дүрэмд Ахмадын сангийн зохицуулалт нэмж тусган нэмэлт, өөрчлөлт оруулсан;
6. ХасБанк болон түүний толгой компани болох ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК (ТСН)-ийн хооронд 2024 оны 05 дугаар сарын 17-ны өдөр байгуулсан Нэгтгэх гэрээ болон Нэгтгэх нөхцөл, журамд нэмэлт, өөрчлөлт оруулсан;
7. ХасБанкны Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны төсвийг баталсан.

Эдгээр тогтоолуудтай Монголын хөрөнгийн бирж болон ХасБанкны цахим хуудсаар дамжуулан танилцана уу. <https://xacbank.mn/mn/shareholders-meeting>

2. Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ") болон ТУЗ-ийн дэргэдэх хорооны хурал

Банкны ТУЗ нь 2025 оны эхний хагас жилд 2 удаагийн ээлжит хурал болон 3 удаагийн ээлжит бус хурлыг оролцуулан нийт 5 удаа хуралдаж, 4 удаа цахимаар санал хураан, нийт 28 тогтоол шийдвэрийг гаргаж ажилласан байна. ТУЗ-ийн ээлжит хурал тус бүрээр ТУЗ-ийн хурлын өмнөх шийдвэр, зөвлөмжийн дагуу авсан арга хэмжээний талаарх мэдээллийг ТУЗ-д танилцуулдаг.

2025 оны эхний хагас жилд ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо 3 удаа хуралдаж (бие даасан хоёр хороо болон өөрчлөн байгуулагдахаас өмнө), Засаглал, цалин урамшууллын хороо 1 удаа цахим санал хураан, Нэр дэвшүүлэх хороо 1 удаа хуралдаж, Эрсдэлийн удирдлагын хороо 2 удаа хуралдаж, 9 удаа цахимаар санал хураан, Аудитын хороо 2 удаа хуралдаж, ТУЗ-д холбогдох зөвлөмж гаргаж ажилласан байна.

3. ТУЗ-ийн үйл ажиллагаа:

Компанийн тухай хуульд заасан хувьцаат компанийн тусгай зохицуулалтууд, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн актууд, Компанийн засаглалын кодексийн шаардлагад нийцүүлэн ХасБанкны ТУЗ-өөс 2025 оны эхний хагас жилд дараах журам, төлөвлөгөө, хөтөлбөрийг шинээр баталж нэмэлт өөрчлөлт оруулж болон шинэчлэн баталсан. Үүнд:

Шинээр баталсан:

1. Засаглал, цалин урамшууллын хорооны дүрэм-Санхүүгийн зохицуулах хорооноос ирүүлсэн зөвлөмжийн дагуу Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хороог Нэр дэвшүүлэх хороо болон Засаглал, цалин урамшууллын хороо болгон бие даасан хоёр хороонд хувааж өөрчлөн байгуулсантай холбогдуулан тус хорооны дүрмийг шинээр баталсан.
2. Нэр дэвшүүлэх хорооны дүрэм-Санхүүгийн зохицуулах хорооноос ирүүлсэн зөвлөмжийн дагуу Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хороог Нэр дэвшүүлэх хороо болон Засаглал, цалин урамшууллын хороо болгон бие даасан хоёр хороонд хувааж өөрчлөн байгуулсантай холбогдуулан тус хорооны дүрмийг шинээр баталсан.
3. ТУЗ-ийн 2025 оны сургалтын хөтөлбөр – ХасБанкны засаглалын төлөвлөгөө 2023-2026-д тусгасны дагуу, Банкны стратегийн удирдлага, хяналтыг хэрэгжүүлэх ТУЗ-ийн гишүүдийн холбогдох ур чадвар, мэдлэгийг дээшлүүлэх үүднээс 2025 оны сургалтын хөтөлбөрийг баталсан;
4. Хувьцаа эргүүлэн худалдан авах хөтөлбөр- ХасБанк өөрийн жижиг хувьцаа эзэмшигчдийн хувьцааны хөрвөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор 2024 оны 2 дугаар хагасаас хойш хувьцаа эргүүлэн худалдан авах хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж байна.

Нэмэлт өөрчлөлт оруулсан:

1. ХасБанк ХК-ийн Дүрэм- Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хороог Нэр дэвшүүлэх хороо болон Засаглал, цалин урамшууллын хороо болгон бие даасан хоёр хороонд хувааж өөрчлөн байгуулах, Ахмадын сангийн зохицуулалт нэмж тусган нэмэлт, өөрчлөлт оруулсан.
2. Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороог хуваахтай холбогдуулан хороодын шинэ бүтцийн дагуу Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны талаар дурдсан дараах дотоод журам, бодлогын баримт бичигт ("Дотоод журмууд") нэмэлт өөрчлөлт оруулсан.
 - i. Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам;
 - ii. Гүйцэтгэх удирдлагын залгамж халааг бэлдэх бодлого;
 - iii. Төлөөлөн удирдах зөвлөлийн үнэлгээний журам;
 - iv. Оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах журам;

- v. ХасБанкны Засаглалын кодекс;
- vi. Ажилтны зээлийн ерөнхий журам;
- vii. Төлөөлөн удирдах зөвлөлийн цалин хөлс болон нөхөн төлбөрийн ерөнхий журам.

3. ХасБанкны Тогтворжуулах төлөвлөгөө- банкнийг тогтворжуулах төлөвлөгөө ашиглах товч заавар болон эрсдэлийн түвшин тус бүрд авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх төлөвлөгөөг нэмж тусгах байдлаар Тогтворжуулах төлөвлөгөөнд нэмэлт оруулсан.

Шинэчлэн баталсан:

1. ХасБанкны Тогтворжуулах төлөвлөгөө- Банкны тухай хууль болон Банкнийг тогтворжуулах төлөвлөгөө боловсруулах батлах, хэрэгжүүлэх журмын дагуу ХасБанкны Тогтворжуулах төлөвлөгөөг баталсан.

2. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгон шалгаруулах, нэр дэвшүүлэх ерөнхий журмыг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгон шалгаруулах, нэр дэвшүүлэх, түүний залгамж халааг бэлдэх ерөнхий журам нэртэйгээр шинэчлэн найруулж баталсан.

4. Ёс зүйн кодекс, сонирхлын зөрчил ба толилуулга

Банкны ёс зүйн хэм хэмжээ нь чин сэтгэлээсээ байх, үнэнч байх, шударга байх, ил тод байх зарчмуудад үндэслэдэг. ХасБанк нь хууль ёсны бөгөөд ёс зүйтэй бизнесийн үйл ажиллагаа явуулах, дотооддоо ёс зүйт зан үйлийн дээд стандартыг баримтлан “ТУЗ-ийн гишүүд болон ажилтнуудын ёс зүйн кодекс ба сонирхлын зөрчлийн ерөнхий журам”-ыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна. ТУЗ-ийн болон гүйцэтгэх удирдлагын бүх гишүүд өөрийн холбогдох этгээдийн мэдээллийг өөрчлөлт орох тухай бүр мэдэгдэхээс гадна жилд 2 удаа бататгах толилуулгын хуудсыг үйлдэж, сонирхлын зөрчил үүсэж болзошгүй нөхцөл байдлыг урьдчилан тогтоох боломжийг ханган ажиллаж байна. Мөн түүнчлэн, ТУЗ-ийн гишүүд ТУЗ-ийн хурал эхлэхэд, мөн хурлын туршид хэлэлцэх асуудалтай холбоотой аливаа сонирхлын зөрчил байвал түүнийгээ мэдэгддэг ба Компанийн тухай хуулийн дагуу уг гишүүн санал хураалтад оролцдоггүй.

ХасБанк нь “Сонирхлын зөрчилтэй этгээд болон холбогдох этгээдтэй хэлцэл хийх журам”-ыг баримтлан өөрийн ердийн үйл ажиллагааны хүрээнд бусад этгээдтэй хийх хэлцлээс хөнгөлөлттэй нөхцөлөөр сонирхлын зөрчилтэй этгээдтэй хэлцэл хийх, улмаар хувьцаа эзэмшигчдийн нийтлэг ашиг сонирхол зөрчигдөхөөс сэргийлэн ажиллаж байна. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.2.4 дэх заалтад заасны дагуу ХасБанк нь холбогдох этгээд болон сонирхлын зөрчилтэй хэлцлийн мэдээллийг банкны өөрийн цахим хуудсаар болон Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлж ажиллаж байна.

5. Банкны оролцогч талуудтай харилцах харилцаа

ХасБанк нь холбогдох дотоод журмын дагуу хувьцаа эзэмшигчтэй тусгай дугаар (+976-8508-1888) болон цахим шуудан (investor-relations@xacbank.mn)-гаар харилцан ажиллаж байна. Түүнчлэн “Оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах журам”-д заасны дагуу банкны урт хугацааны үнэ цэнийг бий болгох гадаад болон дотоод оролцогч талуудтай үр дүнтэйгээр харилцаж, хамтран ажиллах чиглэлд анхаарч өөрийн xacbank.mn цахим хуудсаар дамжуулан оролцогч талуудад мэдээллийг тогтмол хүргэн ажиллаж байна.

6. Мэдээллийн ил тод байдал

ХасБанк нь “Мэдээллийг ил тод болгох ерөнхий журам”-ыг баримтлан өөрийн хувьцаа эзэмшигчид болон эрх бүхий байгууллагуудад банкны талаарх мэдээллийг холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагын дагуу ил тод, тухай бүр тайлагнан ажиллаж байна. Холбогдох мэдээлэлтэй Монголын хөрөнгийн бирж болон ХасБанкны цахим хуудсаар дамжуулан танилцах бүрэн боломжтой.

Овог, нэр: Г.Цэвэгжав
Албан тушаал: Гүйцэтгэх захирал

Гарын үсэг:

(Тамга/тэмдэг)




Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Г.Эрдэнэбаяр
Албан тушаал: Санхүү хариуцсан захирал

Гарын үсэг:

Овог, нэр: Н.Мөнхцэлмэг
Албан тушаал: Хууль хариуцсан захирал бөгөөд ТУЗ-ийн нарийн бичгийн дарга


Гарын үсэг:



Мэдээлэл бэлтгэн, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Г.Тамир
Албан тушаал: Санхүү удирдлага олон улсын харилцааны газрын захирал

Гарын үсэг:



	Балансын зүйл	Эцсийн үлдэгдэл /2024.12.31/	Эцсийн үлдэгдэл /2025.06.30/
1	ХӨРӨНГӨ		
1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	1,895,273,697,466.20	1,756,797,115,510.04
1.1.1	Бэлэн мөнгө	33,011,522,688.03	39,638,278,738.20
1.1.2	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан мөнгө (3 хүртэлх сарын хугацаатай)	773,667,632,339.11	568,953,260,813.39
1.1.3	Мөнгөтэй адилтгах хөрөнгө	1,085,262,868,849.46	1,147,216,166,059.20
1.1.4	Мөнгөн хөрөнгөнд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	3,331,673,589.60	989,409,899.24
1.2	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө	397,890,873,112.18	401,980,634,021.24
1.2.1	Монголбанкинд байршуулсан хөрөнгө	398,103,270,284.07	402,195,214,338.58
1.2.2	Бусад банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө	-	-
1.2.3	Бусад хөрөнгө	-	-
1.2.4	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгөнд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	-	-
1.2.5	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн эрсдэлийн сан	(212,397,171.89)	(214,580,317.34)
1.3	Хөрөнгө оруулалт	164,840,923,389.61	135,737,516,925.28
1.3.1	Арилжааны үнэт цаас	-	-
1.3.2	Борлуулахад бэлэн үнэт цаас	110,519,731,431.07	113,920,177,866.15
1.3.3	Хугацааны эцэс хүртэл эзэмших үнэт цаас	40,000,000,000.00	16,666,888,069.98
1.3.4	Зээл ба авлага гэж ангилсан бусад үнэт цаас	-	-
1.3.5	Хараат, хамтын хяналттай, охин компанид оруулсан хөрөнгө оруулалт	-	-
1.3.6	Барьцаанд байгаа үнэт цаас	9,000,000,000.00	-
1.3.7	Үнэт цаасанд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	7,014,934,028.89	6,566,337,669.41
1.3.8	Үнэт цаасны эрсдэлийн сан	(1,693,742,070.35)	(1,415,886,680.25)
1.4	Зээл (цэвэр дүнгээр)	3,682,590,671,960.92	4,209,127,614,624.31
1.4.1	Хэвийн зээл	3,555,205,923,094.53	4,040,980,794,622.95
1.4.2	Хугацаа хэтэрсэн зээл	67,879,360,313.83	88,024,422,912.39
1.4.3	Хэвийн бус зээл	14,110,460,955.16	25,065,618,042.18
1.4.4	Эргэлзээтэй зээл	12,813,432,207.54	24,654,716,433.92
1.4.5	Муу зээл	47,383,379,858.50	42,347,152,210.30
1.4.6	Зээлийн хойшлогдсон төлбөр	(18,472,474,486.19)	(21,022,303,592.23)
1.4.7	Зээлд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	62,436,985,777.13	74,297,242,925.19
1.4.8	Зээлийн эрсдэлийн сан	(58,766,395,759.58)	(65,220,028,930.38)
1.5	Дериватив санхүүгийн хөрөнгө	10,050,723,082.09	65,524,840,972.27
1.6	Бусад санхүүгийн хөрөнгө	15,847,030,662.03	10,509,331,462.50
1.6.1	Бусдаас авах авлага (цэвэр дүнгээр)	15,847,030,662.03	10,509,331,462.50
1.6.2	Банк, салбар хоорондын тооцоо	-	-
1.6.3	Өмчлөх бусад хөрөнгө (цэвэр дүнгээр)	-	-
1.6.4	Бусад	-	-
1.7	Бусад санхүүгийн бус хөрөнгө	66,304,075,963.19	83,381,523,202.11
1.7.1	Бусад тооцоо	38,137,976,591.44	48,882,638,433.07
1.7.2	Бараа материал, үнэ бүхий зүйл	2,913,396,664.02	4,082,507,118.28
1.7.3	Үнэт металл (цэвэр дүнгээр)	724,526,844.53	2,721,819,596.79
1.7.4	Өмчлөх бусад хөрөнгө (цэвэр дүнгээр)	3,901,079,873.91	4,823,639,278.21
1.7.5	Татварын авлага	49,774,584.08	21,500,724.33
1.7.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	11,942,798,351.54	9,345,098,772.47
1.7.7	Бусад	8,634,523,053.68	13,504,319,278.96
1.8	Үндсэн хөрөнгө	71,071,813,851.88	75,672,585,359.69
1.9	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	-	-
1.10	Борлуулах зориулалттай хөрөнгө	1,089,948,722.66	171,850,000.00
1.11	Биет бус хөрөнгө	16,833,960,840.69	15,948,195,677.15
	Нийт хөрөнгийн дүн	6,321,793,719,051.46	6,754,851,207,754.59
2	ӨР ТӨЛБӨР		
2.1	Харилцах	817,461,963,217.99	669,724,902,706.40
2.1.1	Харилцах дансны нэрлэсэн үлдэгдэл	817,461,963,217.99	669,724,902,706.40
2.1.2	Харилцах дансанд хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	-	-
2.2	Хадгаламж	2,535,432,581,681.66	2,656,965,098,635.44
2.2.1	Хугацаагүй хадгаламж	200,924,056,034.28	194,970,795,758.06
2.2.2	Хугацаатай хадгаламж	2,305,572,882,340.47	2,430,569,232,018.87
2.2.3	Бусад төрлийн хадгаламж	13,361,723,903.61	13,988,585,161.58
2.2.4	Хадгаламжинд хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	15,573,919,403.30	17,436,485,696.92
2.3	Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр	2,036,158,841,263.56	2,445,278,288,519.01
2.3.1	Банк, санхүүгийн байгууллагаас байршуулсан харилцах, хадгаламж	332,372,220,873.02	80,008,049,059.71

	Балансын зүйл	Эцсийн үлдэгдэл /2024.12.31/	Эцсийн үлдэгдэл /2025.06.30/
2.3.2	Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл (хугацаа хэтэрсэн зээлийн дүнг оруулсан)	1,688,771,138,578.17	2,351,223,588,144.22
2.3.3	Эх үүсвэрийн хойшлогдсон төлбөр	(11,196,777,411.89)	(17,912,957,781.38)
2.3.4	Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэрт хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	26,212,259,224.26	31,959,609,096.46
2.4	Бусад эх үүсвэр	40,229,669,289.86	34,479,002,196.27
2.4.1	Банкнаас гаргасан өрийн бичиг	-	-
2.4.2	Банкнаас гаргасан үнэт цаас	-	-
2.4.3	Төслийн зээлийн санхүүжилт	14,996,157,806.96	14,992,107,738.76
2.4.4	Буцаан худалдан авах нөхцөлөөр худалдсан үнэт цаас (репо)	8,880,066,833.29	-
2.4.5	Хамтын зээлжүүлэлтийн эх үүсвэр	406,139,892.73	406,089,379.00
2.4.6	Бусад	15,303,350,706.88	19,057,873,571.64
2.4.7	Бусад эх үүсвэрийн хойшлогдсон төлбөр	-	-
2.4.8	Бусад эх үүсвэрт хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	643,954,050.00	22,931,506.87
2.5	Дериватив санхүүгийн өр төлбөр	9,542,836,602.61	4,624,530,424.41
2.6	Бусад санхүүгийн өр төлбөр	68,812,286,617.39	80,849,204,492.17
2.7	Бусад санхүүгийн бус өр төлбөр	82,552,785,616.99	74,711,233,891.23
2.8	Хоёрдогч өглөг	-	-
2.9	Давуу эрхийн хувьцаа (өр төлбөр)	-	-
	Нийт өр төлбөрийн дүн	5,590,190,964,290.05	5,966,632,260,864.93
3	ӨӨРИЙН ХӨРӨНГӨ		
3.1	Хувь нийлүүлсэн хөрөнгө	105,270,000,000.00	105,270,000,000.00
3.1.1	Давуу эрхийн хувьцаа	-	-
3.1.2	Энгийн хувьцаа	105,270,000,000.00	105,270,000,000.00
3.2	Нэмж төлөгдсөн капитал	30,388,870,985.26	30,083,141,303.79
3.3	Халаасны хувьцаа	(29,667,800.00)	(71,644,100.00)
3.4	Дахин үнэлгээний нэмэгдэл	18,352,368,952.90	18,243,888,700.30
3.5	Хуримтлагдсан ашиг, алдагдал	515,406,908,425.23	573,572,351,671.27
3.6	Бусад өөрийн хөрөнгө	62,214,274,198.01	61,121,209,314.30
3.6.1	Хувьцааны опцион	-	-
3.6.2	Нөөцийн сан	11,439,407,367.49	11,439,407,367.49
3.6.3	Ханш, үнэлгээний тэгшитгэлийн сан	-	-
3.6.4	Эрсдэлийн сангийн нөөц	48,433,631,666.99	47,914,178,079.03
3.6.5	Нийгмийн хөгжлийн сан	-	-
3.6.6	Хөрвөх өр төлбөр	-	-
3.6.7	Хувьцааны баталгаа бүхий зээл	-	-
3.6.8	Борлуулахад бэлэн үнэт цаасны дахин үнэлгээний сан	-	-
3.6.9	Хейджийн хэрэгслийн дахин үнэлгээний сан	-	-
3.6.10	Бусад	2,341,235,163.53	1,767,623,867.78
3.7	Өөрийн хөрөнгийн дүн	731,602,754,761.40	788,218,946,889.66
	Өр төлбөр ба өөрийн хөрөнгийн дүн	6,321,793,719,051.45	6,754,851,207,754.59

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

САНХҮҮ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ



Г.ЦЭВЭГЖАВ

Г.ЭРДЭНЭБАЯР

2025 оны Зургаадугаар сар 30

(Төгрөгөөр)

Д/д	Орлого, зардлын зүйл	Өмнөх үеийн /2024.12.31/	Тайлант үеийн /2025.06.30/
1	Хүүгийн орлого	709,149,105,870.88	406,040,128,170.55
1.1	Монголбанкинд байршуулсан хөрөнгийн	13,981,398,788.02	7,757,471,650.75
1.2	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн	5,492,327,612.90	1,697,567,682.49
1.3	Үнэт цаасны	127,469,611,571.81	59,586,965,002.66
1.4	Зээлийн	558,189,091,309.51	328,558,911,079.96
1.5	Бусад хүүгийн орлого	4,016,676,588.64	8,439,212,754.69
2	Хүүгийн зардал	403,329,978,687.44	254,749,733,755.17
2.1	Харилцахад төлсөн хүү	4,020,924,963.66	2,524,951,026.64
2.2	Хадгаламжинд төлсөн хүү	215,421,737,592.31	121,044,758,929.61
2.3	Зээлийн хүүгийн зардал	119,855,922,388.80	75,134,487,528.05
2.4	Үнэт цаасны хүүгийн зардал	663,708,312.20	428,399,648.19
2.5	Бусад хүүгийн зардал	63,367,685,430.47	55,617,136,622.68
3	Хүүгийн цэвэр орлого [(1)-(2)]	305,819,127,183.44	151,290,394,415.38
4	Эрсдэлийн сангийн зардал	126,157,173.97	6,669,890,618.92
4.1	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн	(0.00)	216,257,448.14
4.2	Үнэт цаасны	126,157,173.97	-
4.3	Зээлийн	-	6,453,633,170.78
5	Эрсдэлийн сангийн дараах цэвэр орлого [(3)-(4)]	305,692,970,009.47	144,620,503,796.46
6	Бусад орлого	95,337,414,187.38	43,078,477,830.90
6.1	Хүүгийн бус орлого	77,229,968,399.12	40,548,090,493.20
6.1.1	Арилжааны орлого	11,473,604,576.57	3,441,559,298.18
6.1.2	Ханш, үнэлгээний тэгшитгэлийн орлого	-	4,295,688,479.01
6.1.3	Банкны бүтээгдэхүүнтэй холбоотой үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	61,651,458,617.07	32,641,591,259.92
6.1.4	Бусад хүүгийн бус орлого	4,104,905,205.48	169,251,456.09
6.2	Бусад орлого, олз	18,107,445,788.26	2,530,387,337.70
7	Бусад зардал	170,565,691,963.36	76,653,710,652.14
7.1	Хүүгийн бус зардал	167,421,003,704.91	75,359,890,044.77
7.1.1	Бусад эрсдэлийн сангийн зардал	1,342,765,875.62	244,413,992.82
7.1.2	Арилжааны зардал	-	-
7.1.3	Ханш, үнэлгээний тэгшитгэлийн зардал	5,262,173,558.95	-
7.1.4	Хураамж, шимтгэлийн зардал	17,886,449,861.04	10,418,996,330.55
7.1.5	Үйл ажиллагааны бусад зардал	142,929,614,409.30	64,696,479,721.40
7.2	Бусад зардал, гарз	3,144,688,258.45	1,293,820,607.37
8	Татварын өмнөх ашиг, алдагдал (5+6-7)	230,464,692,233.50	111,045,270,975.22
9	Орлогын татварын зардал	58,784,403,852.13	25,103,277,108.75
10	Татварын дараах ашиг, алдагдал (8-9)	171,680,288,381.37	85,941,993,866.47
11	Зогсоосон үйл ажиллагааны цэвэр орлого, зардал	-	-
12	Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал (10+11)	171,680,288,381.37	85,941,993,866.47
13	Бусад дэлгэрэнгүй орлого	(856,106,154.33)	(573,611,295.75)
13.1	Үндсэн хөрөнгө ба биет бус хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансны өсөлт, бууралт	-	-
13.2	Борлуулахад бэлэн үнэт цаасны дахин үнэлгээний өсөлт, бууралт	(856,106,154.33)	(573,611,295.75)
13.3	Ханш, үнэлгээний тэгшитгэлийн сангийн өсөлт, бууралт	-	-
13.4	Эрсдэлийн сангийн нөөцийн өсөлт, бууралт	-	-
13.5	Бусад	-	-
14	Тайлант хугацааны нийт дэлгэрэнгүй орлогын дүн (10+11)	170,824,182,227.04	85,368,382,570.72

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

САНХҮҮ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ

Г.ЦЭВЭГЖАВ

Г.ЭРДЭНЭБАЯР





ХАСБАНКНЫ ОМЧИЙН ООРЧЛОЛТИЙН ТАЙЛАН

2025 оны Зургаадугаар сар 30

Оөрийн хөрөнгийн зүйл	Хувь нийлүүлсэн хөрөнгө	Нэмж толөгдсөн капитал	Халаасны хувидаа	Дахин үнэлгээний нэмэгдэл	Бусад өөрийн хөрөнгө	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2023 оны 12-р сарын 31-ний өдрийн үлдэгдэл	105,270,000,000.00	30,586,768,164.70	-	18,528,613,201.77	67,890,292,259.64	399,787,063,887.69	622,062,737,513.81
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын оорчлолтийн нөлөө, алдааны залруулга							
Залруулсан үлдэгдэл	105,270,000,000.00	30,586,768,164.70	-	18,528,613,201.77	67,890,292,259.64	399,787,063,887.69	622,062,737,513.81
Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал	-	-	-	-	-	171,680,288,381.37	171,680,288,381.37
Бусад дэлгэрэнгүй орлого					(856,106,154.33)		(856,106,154.33)
Омчил гарсан өөрчлөлт	-	(197,897,179.44)	(29,667,800.00)	-	(4,819,911,907.30)	4,819,911,907.30	(227,564,979.44)
Хуваарилсан ногдол ашиг	-	-	-	(176,244,248.87)		(61,056,600,000.00)	(61,056,600,000.00)
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн						176,244,248.87	
2024 оны 12-р сарын 31-ний өдрийн үлдэгдэл	105,270,000,000.00	30,388,870,985.26	(29,667,800.00)	18,352,368,952.90	62,214,274,198.01	515,406,908,425.23	731,602,754,761.40
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын оорчлолтийн нөлөө, алдааны залруулга							
Залруулсан үлдэгдэл	105,270,000,000.00	30,388,870,985.26	(29,667,800.00)	18,352,368,952.90	62,214,274,198.01	515,406,908,425.23	731,602,754,761.40
Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал	-	-	-	-	-		-
Бусад дэлгэрэнгүй орлого					(573,611,295.75)		(573,611,295.75)
Омчил гарсан өөрчлөлт	-	(305,729,681.47)	(41,976,300.00)	-	(519,453,587.96)	519,453,587.97	(347,705,981.47)
Хуваарилсан ногдол ашиг	-	-	-	-		(28,404,484,461.00)	(28,404,484,461.00)
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн				(108,480,252.60)		108,480,252.60	
2025 оны 6-р сарын 30-ны өдрийн үлдэгдэл	105,270,000,000.00	30,083,141,303.79	(71,644,100.00)	18,243,888,700.30	61,121,209,314.30	573,572,351,671.27	788,218,946,889.66

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Г.ЦЭВЭГЖАВ

САНХҮҮ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ

Г.ЭРДЭНЭБАЯР



2025 оны Зургаадугаар сар 30

(Төгрөгөөр)

	Үзүүлэлт	Өмнөх үеийн /2024.12.31/	Тайлант үеийн /2025.06.30/
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ:	***	***
1.1	Орлогын татварын өмнөх ашиг (алдагдал)	233,252,053,739.36	108,256,367,630.91
1.2	Орлого, зардлын тохируулга:	(291,323,924,519.89)	(136,363,068,969.48)
1.2.1	Эрсдэлийн сангийн зардал (+)	(2,098,222,821.63)	6,422,374,918.95
1.2.2	Элэгдэл, хорогдлын зардал (+)	16,656,322,048.89	9,606,917,509.40
1.2.3	Ханш, үнэлгээний тэгшитгэлийн орлого (-), зардал (+) (Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөөс бусад)	-	-
1.2.4	Хуримтлуулсан хүүгийн орлого (-)	(709,149,105,870.88)	(406,040,128,170.55)
1.2.5	Хуримтлуулсан хүүгийн зардал (+)	403,329,978,687.44	254,749,733,755.17
1.2.6	Хөрөнгө данснаас хассаны олз (-), гарз (+)	(62,896,563.70)	(1,101,966,982.46)
1.2.7	Бусад олз (-), гарз (+)	-	-
1.3	Хөрөнгө, өр төлбөрийн өөрчлөлтийн тохируулга:	(462,819,052,597.69)	(791,866,383,316.12)
1.3.1	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн өсөлт (-), бууралт (+)	(158,355,145,501.36)	(4,091,944,054.51)
1.3.2	Арилжааны үнэт цаасны өсөлт (-), бууралт (+)	-	-
1.3.3	Зээлийн өсөлт (-), бууралт (+)	(942,605,787,161.85)	(521,130,318,686.13)
1.3.4	Бусад санхүүгийн хөрөнгийн өсөлт (-), бууралт (+)	60,567,377,598.97	(50,245,528,279.01)
1.3.5	Бусад санхүүгийн бус хөрөнгийн өсөлт (-), бууралт (+)	(12,392,974,012.32)	(18,186,013,683.62)
1.3.6	Харилцах, хадгаламжийн өсөлт (+), бууралт (-)	529,725,884,518.15	(28,067,109,851.44)
1.3.7	Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэрийн өсөлт (+), бууралт (-)	85,806,967,544.13	(178,464,245,831.75)
1.3.8	Бусад санхүүгийн өр төлбөрийн өсөлт (+), бууралт (-)	(36,211,538,155.95)	5,313,439,073.25
1.3.9	Бусад санхүүгийн бус өр төлбөрийн өсөлт (+), бууралт (-)	10,646,162,572.54	3,005,337,997.10
1.4	Бусад тохируулга:	236,761,192,350.26	119,683,299,504.63
1.4.1	Авсан хүү (+)	694,021,294,248.83	394,598,796,675.12
1.4.2	Төлсөн хүү (-)	(390,320,134,510.56)	(247,760,840,132.49)
1.4.3	Орлогын татварын төлөлт (-)	(65,166,388,391.46)	(27,154,657,038.01)
1.4.4	Эрсдэлийн сангаас хаасан зээл, авлага (-)	(1,773,578,996.56)	-
1.4.5			
1.5	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(284,129,731,027.96)	(700,289,785,150.06)
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ:	***	***
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	4,929,130,398.96	30,127,948,503.93
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	7,916,511.42	810,000.00
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.3	Хөрөнгө оруулалтын зориулалттай хөрөнгө борлуулсны орлого		
2.1.4	Охин компани, хараат компани, хамтын хяналттай аж ахуйн нэгжид оруулсан хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
2.1.5	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	2,241,413,887.55	292,400,000.00
2.1.6	Зээл ба авлага гэж ангилан хорогдуулсан өртгөөр бүртгэсэн хөрөнгө оруулалт		
2.1.7	Борлуулахад бэлэн үнэт цаас борлуулсны орлого	2,679,799,999.99	4,834,738,503.93
2.1.8	Хугацааны эцэс хүртэл эзэмших үнэт цаас борлуулсны орлого	-	25,000,000,000.00
2.1.9	Хүлээн авсан ногдол ашиг		
2.1.10	Бусад мөнгөн орлого	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	(55,650,330,534.74)	(12,004,287,678.50)
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	14,426,045,543.97	9,681,262,465.70
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	1,224,284,990.77	685,807,849.67
2.2.3	Хөрөнгө оруулалтын зориулалттай хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.4	Охин компани, хараат компани, хамтын хяналттай аж ахуйн нэгжид оруулсан хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
2.2.5	Зээл ба авлага гэж ангилан хорогдуулсан өртгөөр бүртгэсэн хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
2.2.6	Борлуулахад бэлэн үнэт цаас олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.7	Хугацааны эцэс хүртэл эзэмших үнэт цаас олж эзэмшихэд төлсөн	40,000,000,000.00	1,637,217,363.13
2.2.8	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.9	Бусад мөнгөн зарлага	-	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(50,721,200,135.78)	18,123,660,825.43
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ:	***	***
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	737,872,901,002.16	831,055,929,022.09
3.1.1	Бусад эх үүсвэр татаж хүлээн авсан	737,565,385,353.51	831,055,929,022.09
3.1.2	Хоёрдогч өглөгөөс хүлээн авсан	-	-
3.1.3	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
3.1.4	Төрөл бүрийн хандив		
3.1.5	Бусад	307,515,648.65	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	(305,896,264,966.54)	(287,366,386,653.62)
3.2.1	Бусад эх үүсвэрт төлсөн	238,665,335,538.20	254,349,230,357.53
3.2.2	Хоёрдогч өглөгт төлсөн		
3.2.3	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
3.2.4	Хувьцаа буцаан худалдан авахад төлсөн	227,564,979.44	347,705,981.48
3.2.5	Төлсөн ногдол ашиг	61,056,600,000.00	28,404,484,461.00
3.2.6	Бусад	5,946,764,448.90	4,264,965,853.61
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	431,976,636,035.62	543,689,542,368.47
4	Валютын ханшийн зөрүү		
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	97,125,704,871.88	(138,476,581,956.17)
6	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,798,147,992,594.32	1,895,273,697,466.20
7	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,895,273,697,466.20	1,756,797,115,510.04

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

САНХҮҮ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ

Г ЦЭВЭГЖАВ

Г ЭРДЭНЭБАЯР



2025 оны Зургаадугаар сар 30

(Төгрөгөөр)

№	Дансны нэр	Дүн
1	Зээл, зээлтэй адилтгах хөрөнгөнд хамаарах үүрэг	322,820,128,334.8
2	Барьцаа хөрөнгө	7,092,376,077,953.2
3	Тэнцлээс хассан хөрөнгө	80,261,333,103.4
4	Дериватив санхүүгийн хэрэгсэл	2,326,870,542,112.8
5	Харилцагчийн өмнөөс батлан даасан хөрөнгө	-
6	Барьцаанд тавьсан хөрөнгө	-
7	Тэнцлийн гадуурх бусад дансууд	369,315,420,723.3
Нийт		10,191,643,502,227.3

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

САНХҮҮ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ



Г.ЦЭВЭГЖАВ

Г.ЭРДЭНЭБАЯР